

“НИЙГМИЙН ЗАЙЛШГҮЙ ХЭРЭГЦЭЭГ ҮНДЭСЛЭН ГАЗАР ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙГ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Энэхүү урьдчилсан тандан судалгааг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хууль бусад холбогдох хуулиудад зааснаар газрыг эргүүлэн авах, солих, дайчлан авах, хураан авах, нийтийн эдэлбэрт ашиглах, хот, сууриныг дахин хөгжүүлэх зорилгоор газар чөлөөлөх гэсэн ойлголтууд байх бөгөөд эдгээрийг тодруулбал:

1. Улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах; шинжлэх ухаан, технологийн сорилт, туршилт болон байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбай байгуулах; улсын чанартай зам, шугам сүлжээ, барилга байгууламж барих болон Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан улсын тусгай хэрэгцээнд газрыг солих буюу эргүүлэн авч болно,

2. Нийгмийн зайлшгүй хэрэгцээ болон байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон, үйлдвэрийн томоохон осол гарсан, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдсан зэрэг гэнэтийн аюул, онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд түүний аюулаас хүн ам, мал, амьтан, эд хөрөнгийг хамгаалах, аврах, хор уршгийг нь арилгах арга хэмжээнд зориулан газрыг дайчлан авах,

3. Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авах,

4. Засгийн газар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглах,

5. Хот, сууриныг дахин хөгжүүлэх буюу хот төлөвлөлтийн шаардлага хангахгүй барилгажсан хэсгийг дахин төлөвлөн барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулган шинээр барих, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах, нийтийн эдэлбэрийн газрыг дахин төлөвлөн байгуулах зорилгоор газар эзэмшигч, өмчлөгчтэй гэрээ байгуулах замаар нөхөх олговортойгоор газрыг чөлөөлөхөөр зохицуулсан байна.

Дээрх байдлаар газрыг эргүүлэн авч, дайчлан авч, хураан авч болохоор тодорхойлсон боловч яж, хэрхэн авах үйл ажиллагааны дарааллыг тодорхой зохицуулаагүй орхигдуулсан байна.

Харин эдгээрээс улсын тусгай хэрэгцээнд болон хот сууриныг дахин хөгжүүлэх зорилгоор газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах, солих, чөлөөлөх асуудал тодорхой хэмжээнд зохицуулагдсан боловч энэ нь бүрэн биш улмаар “Нийгмийн зайлшгүй хэрэгцээ” гэдэгт юуг, ямар хэрэгцээг ойлгох талаар тодорхой бус, тохиролцоонд хүрээгүй, гэрээ байгуулагдаагүй тохиолдолд газрыг хэрхэн чөлөөлөх, нөхөх олговрыг хэрхэн тооцох талаар зохицуулалт байхгүй байгаа болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Тулгамдаж байгаа асуудлуудын мөн чанар, цар хүрээг тоймлон тодорхойлбол:

1. Үндсэн хуульд тодорхойлсон “Нийгмийн зайлшгүй хэрэгцээ” гэдэг ойлголтыг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Тухайлбал, энэ ойлголт нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжуудаас зөвхөн Патентийн тухай хуульд “үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээ” гэж томъёологдсон байна. Мөн нийгмийн зайлшгүй хэрэгцээ нь улсын тусгай хэрэгцээтэй нэг ойлголт мөн эсэх, эсвэл ялгаатай эсэх нь ойлгомжгүй байна. Өнөөдрийн байдлаар нөхөх олговортойгоор газар чөлөөлөх үйл ажиллагааг ихэвчлэн нийгмийн үйлчилгээг иргэдэд тэгш хүргэх үүднээс нийгмийн болон инженерийн дэд бүтцийг бий болгох зорилгоор хэрэгжүүлж байгаа хэдий ч эрх зүйн орчин бүрдээгүйгээс иргэний эд хөрөнгийн болон бусад эрх зөрчигдөх нөхцөлийг үүсгэж байна.

Хэрэв нийгмийн зайлшгүй хэрэгцээг улсын тусгай хэрэгцээ мөн гэж үзвэл тусгай хэрэгцээний ангилалд нэмж оруулах шаардлагатай юм.

Хэдийгээр Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудад улсын тусгай хэрэгцээнд зориулан газрыг чөлөөлөх талаар зарим зохицуулалтууд байгаа боловч тэдгээр нь зөвхөн гэрээний үндсэн дээр харилцан тохиролцоно гэж заасан тул хэрэв иргэнтэй тохиролцож чадаагүй тохиолдолд хэрхэн зохицуулах, түүнийг шийдэх хууль эрх зүйн механизм байхгүй байна.

2. Иргэний өмчилсөн газрын хувьд нөхөх олговортойгоор чөлөөлөх нь зайлшгүй бөгөөд харин эзэмшиж, ашиглаж байгаа газрыг хэрхэн чөлөөлөх, нөхөх олговор олгох эсэх асуудал тодорхой зохицуулалтгүй, нэгдсэн ойлголтгүй байна. Тухайлбал: эзэмшил газрыг чөлөөлөхдөө газраас бусад эд хөрөнгөнд нөхөх олговор олгож байгаа практик тогтоод байна. Тэгвэл тухайн газар эзэмших эрхийг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар авсан бол нөхөх олговор тооцох эсэх, газар эзэмших эрхийн баталгааг хэрхэн хангах нь тодорхойгүй байна.

3. Нөхөх олговрын үнэлгээг хэрхэн тогтоох талаар мөн тодорхой нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө” гэж, мөн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсэгт “Дайчлан авсны улмаас газар өмчлөгч иргэнд учирсан хохирлыг нь бүрэн хэмжээгээр нөхөн төлнө.”, “Дайчлан авсан газрыг эргүүлэн өгөх боломжгүй болсон тохиолдолд өмчлөгчид нь уг газрын үнэ, хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож нөхөн төлөх буюу дайчлан авсан газраас төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй өөр газрыг өмчлүүлж учирсан хохирлыг нөхөн төлнө” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “өмчийн газрыг нь сольж байгаа тохиолдолд иргэний хүсэлтийг үндэслэн өмчилж байсан газраас нь төлөв байдал, чанарын хувьд дордохооргүй газар түүнд өмчлүүлэх”; “газрыг нь эргүүлэн авч байгаа тохиолдолд газрынх нь үнийг төлөх”; “иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх”; “өмчлөгчөөс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх”; “газрыг улсын тусгай хэрэгцээг үндэслэн солих буюу эргүүлэн авснаас өмчлөгчид учруулах

хохирлыг иргэний хууль тогтоомжид заасны дагуу бүрэн хэмжээгээр нөхөн төлөх" гэж заасан. Дээрх хууль тогтоомжуудыг үндэслэн дараах нөхөх олговрыг олгоно.

Нөхөх олговрын харьцуулалт

Солих үеийн нөхөх олговор	Эргүүлэн авах үеийн нөхөх олговор	Дайчлан авах үеийн нөхөх олговор
иргэний хүсэлтийг үндэслэн өмчилж байсан газраас нь төлөв байдал, чанарын хувьд дордоогоргүй газрыг өмчлүүлэх	газрын үнэ	газрын үнэ
иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх	иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх	иргэний өмчилж байсан газарт байгаа үл хөдлөх эд хөрөнгийн үнийг төлөх
өмчлөгчөөс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх";	өмчлөгчөөс тухайн газарт зарцуулсан хөрөнгийг нөхөн төлөх";	хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож нөхөн төлөх эсвэл /буюу/ дайчлан авсан газраас төлөв байдал, чанарын хувьд дордоогоргүй өөр газрыг өмчлүүлж учирсан хохирлыг нөхөн төлнэ"
сольж авснаас өмчлөгчид учруулах хохирлыг	эргүүлэн авснаас өмчлөгчид учруулах хохирлыг	хохирлыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцож нөхөн төлөх эсвэл /буюу/ дайчлан авсан газраас төлөв байдал, чанарын хувьд дордоогоргүй өөр газрыг өмчлүүлж учирсан хохирлыг нөхөн төлнэ"

Гэвч газрын үнэ, тухайн газарт зарцуулсан хөрөнгийн үнэлгээ, учирсан хохирол зэргийг хэрхэн тооцож олгох нь тодорхойгүй байгаа юм.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх байгаа этгээд:

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нэлөөлж буй хэлбэр
1 Иргэд	Иргэний газартай холбоотой эрхийн баталгаа сүл байна. Тухайлбал: төрөөс иргэний өмчлөлийн газрыг хуульд заасан үндэслэлээр нөхөн олговортойгоор эргүүлэн авахдаа тухайн газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнээр өмчлөгчтэй тохиролцно гэж хуульд заасан хэдий ч зах зээлийн үнэ цэнийг хэрхэн тогтоох талаар нарийвчилсан зохицуулалт хуульчлагдаагүй байгаа нь газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдөх нөхцөлийг бүрдүүлж байна.
2 Төр /нийтийн эрх ашиг/	Нийгмийн үйлчилгээг иргэдэд тэгш хүргэх үүднээс нийгмийн болон инженерийн дэд бүтцийг бий болгох зорилгоор хэрэгжүүлж байгаа хэдий ч эрх зүйн орчин бүрдээгүйгээс төсөл хэрэгжихгүй байх, удаашрах үүнээс үүдэн нийтийн эрх ашиг хөндөгдөх нөхцөл үүсэж байна.
3 Хөрөнгийн үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж, үнэлгээчин	Нөхөх олговрын үнэлгээ тооцох аргачлал, газрын зах зээлийн үнэлгээ тодорхойгүйгээс үнэлгээг бодитой тогтооход хүндрэлтэй байдаг.

Дээрх сөрөг нөлөөллийн улмаас газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх ашиг зөрчигдөх нөхцөл бүрдэж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГО

Тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд дараах зорилгуудыг дэвшүүлж байна. Үүнд:

А. Нийгмийн зайлшгүй хэрэгцээг тодорхойлж, газар чөлөөлөх эрх зүйн үндсийг тодорхойлох;

Б. Нийтийн эрх ашгийг хамгаалах, хангах үүднээс нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим, хэрэгжүүлэх арга хэмжээ /шат дараалсан үйл ажиллагаа/-г тодорхой болгох;

В. Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн төрлөөс шалтгаалан нөхөх олговрын бүрдэл, үнэлгээг тооцох аргачлалыг тодорхой болгох;

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

Зохицуулалтын хувилбаруудын зорилгод хүрэх байдал болон тэдгээрийн зерэг, сөрөг талыг хүснэгт 1-ээр үзүүлэв.

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх зерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
А. Нийгмийн зайлшгүй хэрэгцээг тодорхойлж, газар чөлөөлөх эрх зүйн үндсийг тодорхойлох;			
1 Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх ба сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн серөг
2 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх			
3 Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх			
4 Төрөөс санхүүгийн интервенци хийх			
5 Захиргааны шийдвэр гаргах			
6 Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Үндсэн хуульд заасанчлан иргэний өмчлөх эрхийг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлах тул хуулиар зохицуулах шаардлагатай.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд газар чөлөөлөх үйл ажиллагаанд иргэний газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн баталгааг хангах нөхцөл бүрдэнэ.	Үр дүнтэй
Б. Нийтийн эрх ашгийг хангах үүднээс газар чөлөөлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой болгох;			

1	Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх ба сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх			
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх			
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх			
5	Захиргааны шийдвэр гаргах			
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Газар чөлөөлөх үйл ажиллагаанд иргэний өмчийн эрхийг хамгаалах, тэгш байдлыг хангах зэрэг зайлшгүй баримтлах зарчмуудыг хуульчлан тогтоох, улмаар албадлага хэрэглэх тохиолдолд энэхүү үйл ажиллагаа нь зөвхөн зайлшгүй тохиолдолд хуульд заасан арга хэлбэрээр гүйцэтгэгдэх зохицуулалтыг бий болгоно.	Нэмэлт зардал гарагчий бөгөөд газар чөлөөлөх үйл ажиллагаанд баримтлах зарчим хэрэгжүүлэх арга хэмжээг хуульчлан өгснөөр газар өмчлөг, эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны эрх хамгаалагдах юм.	Үр дүнтэй

В. Газар эзэмших, ашиглах, өмчлөх эрхийн төрлөөс шалтгаалан нөхөх олговрын бүрдэл, үнэлгээг тооцох ерөнхий аргачлалыг тодорхой болгох;

1	Тэг хувилбар	Зорилгод хүрэх боломжгүй.	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх ба сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх			
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх			
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх			
5	Захиргааны шийдвэр гаргах	Нөхөх олговрын үнэлгээг тооцох аргачлалыг эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр батлан мөрдүүлэх боломжтой.	Тухайн аргачлалын дагуу нөхөх олговрын үнэлгээг хийх боломжтой.	Боломжтой.

6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Нэхөх олговор тооцох үндсэн зарчим, нэхөх олговрын бурдлийг хуулиар тогтоож өгөх шаардлагатай.	Нэмэлт зардал гарагчийг бөгөөд нэхөх олговрын үнэлгээ тооцох эрх зүйн орчин бурдэнэ.	Үр дүнтэй
---	--------------------------------------	--	--	-----------

Дээрх харьцуулсан судалгаанаас үзэхэд асуудлыг шийдвэрлэх зорилгыг хангахад Хууль тогтоомжийн төсөл боловсруулах гэсэн зохицуулалтын хувилбар илүү тохиромжтой байгаа тул үүнийг сонгов.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨ

Сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу өрөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа. Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт /2, 3, 4, 5/-ээс үзнэ үү.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийллээ.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулан батлан хэрэгжүүлэх нь өнөөгийн тулгамдаад байгаа сөрөг үр дагаврыг бууруулах, хяналт, үр дүнг сайжруулах зэрэг асуудлыг цогцоор шийдвэрлэх боломж өндөр байна.

Гэвч энэ зохицуулалт нь шинэ тутам бөгөөд оновчтой хэлбэрээр хуульчлахгүй бол нийгэмд үзүүлэх сөрөг үр дагаврыг нэмэгдүүлэх эрсдэл учирч болох юм.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ

Азийн хөгжлийн банкны Бүс нутгийн техникийн туслалцаа 7566: Нийгмийн хамгааллын тогтолцоог бэхжүүлэх, ашиглах төслийн дэд төсөл. Монгол дахь албадан нүүлгэн суурьшуулалтын хууль эрх зүй, зохицуулалтын орчны шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн Австрали (Виктория муж улс), Польш, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс (БНААУ), Чили, БНХАУ (Өвөр Монголын Өөртөө Засах Орон)-ын туршлага, эрх зүйн орчны судалгааг хавсаргав.

Судалгааны үр дүнд Монгол Улс газар чөлөөлөхтэй холбоотой хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, газар чөлөөлөх үйл ажиллагааны нөлөөлөлд өртөгсдийн хууль ёсны эрх ашиг, өмчийн эрх болон бусад эрхийг хамгаалахтай холбоотой зохицуулалтыг оновчтой болгох зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Бусад улсын туршлагаас суралцаж хамгийн оновчтойг сонгон нэвтрүүлэх

боловжтой бөгөөд ингэхдээ өөрийн орны онцлогт тохируулах нь чухал юм.

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Өнөөдрийн тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийг цогцоор шийдвэрлэх боломжийг хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар хангахаар байна.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 2

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх		1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
1.2. Оролцоог хангах				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгоходоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс тодорхой тохиолдолд албадлага хэрэглэх нөхцөл үүснэ.
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Өмчлөгч, эзэмшигчийн эд хөрөнгийн эрх, бусад эрх хамгаалагдана.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс тодорхой тохиолдолд албадлага хэрэглэх нөхцөл үүснэ.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалzan үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү/ эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 3

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдхөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хориг тавих эсэх			
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (ул хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг чөлөөлнө. Энэ үед газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн эрх хөндөгдөх боловч харилцан тохиролцож нөхөх олговрыг олгоно. Нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс тодорхой тохиолдолд албадан чөлөөлөх нөхцөл үүснэ.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэгээр нөлөөлнө. Сургууль, цэцэрлэг, авто зам г.м нийгмийн дэд

				бүтцүүд байгуулагдах нөхцөл бүрдэнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн болон инженерийн дэд бүтэцгүй суурьшлын бүсүүдэд газар чөлөөлөлтийн үр дүнд тэдгээрийг барьж байгуулснаар тухайн бүсэд оршин суугч иргэдийн эрх ашиг, хэрэгцээ тодорхой үзүүлэлтуудээр хангагдана.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газар чөлөөлөлтэд өртөгсөд бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байсан бол ажлын байраа алдах боловч нөхөх олговроо авна.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газар чөлөөлөлтэд өртөгдсөд бизнесийн үйл ажиллагаа эрхэлж байсан бол ажлын байраа алдах боловч нөхөх олговроо авна,
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсвөөс нөхөх олговрын зардал гарна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэгт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 4

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Бүтээн байгуулалтын нөлөөгөөр ажлын байр бий болох боломжтой.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Газар чөлөөлөлтөд өртөгсөд бизнесийн үйл ажиллагаа, ажлын байраа алдах боловч нөхөх олговорт үндэслэн сэргээх, нүүн шилжих боломжтой авна.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Газар чөлөөлөлтөд өртөгсөд бизнесийн үйл ажиллагаа, ажлын байраа алдах боловч нөхөх олговорт үндэслэн сэргээх, нүүн шилжих боломжтой авна.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Давхардсан үйл ажиллагаа, мэдээллийн сангийн асуудал цэгцэрнэ. Дундын мэдээллийн сантай болсноор иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Давхардсан үйл ажиллагаа, мэдээллийн сангийн асуудал цэгцэрнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хаоллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Маш зөрэг нөлөө үзүүлнэ.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалалт, эрүүл мэнд, боловсролын систем	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Маш зөрэг нөлөө үзүүлнэ.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1. Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хүснэгт 5

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчиний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчиний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эvdэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Газар ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Газрын зориулалтыг өөрчилж болно.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Газрын зориулалтыг өөрчилж болно.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй